



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Амгалан дулааны станц ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/089/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2025 он

Санхүү, нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер Б.Долгорсүрэн

Утас: 261628, Цахим хаяг: dolgorsurenb@audit.gov.mn

Аудитор Г.Оюунтөгөлдөр

Утас: 261740, Цахим хаяг: Oyuntuquuldurg@audit.mn

Си Эс Ай Аудит ХХК-ийн захирал М.Сэвжидмаа
Утас: 70001981, Цахим хаяг: csi_sevjee@cisiaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.17 № 07/1031
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Амгалан дулааны станц ТӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Засгийн газраас хэрэгжүүлж буй Шинэ сэргэлтийн бодлогод тусгасан Эрчим хүчний сэргэлтийн зорилтын хүрээнд Амгалан дулааны станц ТӨХК-ийн 116 МВт хүчин чадалтай нэг зуухаар өргөтгөх төслийн барилга угсралтын ажлыг 2023 оны 4 дүгээр сард эхлүүлсэн. Тус төслийн хөрөнгө оруулагч, захиалагчаар Эрчим хүчний яам, санхүүжүүлэгчээр Монгол Улсын Хөгжлийн банкны охин компани болох Ди Би Эм Лизинг ХХК, ерөнхий гүйцэтгэгчээр БНХАУ-ын Хунан индустриал экүпмент инсталэйшн ХХК, металлургийн зураг төсөл судалгааны хүрээлэн, Монгол Улс дахь зургийн гүйцэтгэгч Интернэшнл повер ХХК-ийн зураг төсвөөр түлхүүр гардуулах нөхцөлтэй "Улаанбаатар хотын зүүн бүсийн дулааны эрчим хүчний хэрэглээний өсөлтийг хангах төсөл"-ийн барилга угсралтын ажлын Эрчим хүчний барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын дүгнэлтийг 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр 07/2025 өдөр гаргасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал

байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Эрчим хүчний сайдын 2024 оны 10 дугаар сарын 04-ны А/216 тушаалаар зорилтот түвшнийг тодотгож 1,079.7 мян.Гкал дулааны эрчим хүчийг үйлдвэрлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 1,041.0 мян.Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэж, нийт 63,224.6 сая төгрөгийн орлого олж, төлөвлөлтөөс 949.2 сая төгрөг буюу 1.5 хувиар буурсан нь гадна агаарын температур С-10-28 градусын хооронд олон жилийн дунджаас илүү дулаарсантай холбоотой байна.

Монгол Улсын Хөгжлийн банкны охин компани болох Ди Би Эм Лизинг ХХК-аас 5 жилийн хугацаатай, SOFR 90 хоногийн хөвөгч хүүгийн нөхцөлтэй 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр СТГ-22/01 дугаар санхүүгийн түрээсийн гэрээг байгуулж, нийт 55,822.2 сая төгрөгийн санхүүгийн түрээсийн үйлчилгээ авч, жилийн эцсийн байдлаар 18,114.5 сая төгрөгийн урт хугацаат санхүүгийн түрээсийн өглөгтэй байна.

Бусад асуудал

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулах ажлыг Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит ХХК-аар гүйцэтгүүлж байгаа тул компанийн онцлог, үйл ажиллагаанд нийцсэн эсэхийг үзэх боломжгүй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АУОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	4,367,018,586.26	410,120,632.41
1.1.2	Дансны авлага	4,933,346,236.71	35,682,590.19
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	536,850,035.04	428,504,220.89
1.1.4	Бусад авлага	18,082,418.01	11,649,963.56
1.1.6	Бараа материал	2,810,084,061.54	3,762,565,378.54
1.1.7	Урьдчилж төлсөн зардал /тооцоо/	499,871,698.75	592,860,948.60
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	13,165,253,036.31	5,241,383,734.19
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	62,006,916,355.57	56,766,384,306.06
1.2.2	Биет бус хөрөнгө	13,055,842,556.79	13,046,626,646.35
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	625,880,046.13	706,393,235.58
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	54,964,854,361.45	61,785,119,475.62
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	130,653,493,319.94	132,304,523,663.61
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	143,818,746,356.25	137,545,907,397.80
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	13,764,603,856.55	8,694,325,467.76
2.1.1.2	Цалингийн өглөг	1,407,867.52	1,142,567.91
2.1.1.3	Татварын өр	3,386,986,747.37	3,081,839,741.94
2.1.1.4	НДШ-ийн өглөг		
2.1.1.08	Урьдчилж орсон орлого		2,449,536.57
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	84,370,494.12	85,446,347.58
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	17,237,368,965.56	11,865,203,661.76
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	29,176,704,889.97	18,077,872,341.41
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	2,394,864,048.78	2,807,971,198.01
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	713,280,779.20	627,834,431.62
2.1.2.5	Бусад хөрөнгө оруулалт		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	32,284,849,717.95	21,513,677,971.04
2.2	Өр төлбөрийн нийт дүн	49,522,218,683.51	33,378,881,632.80
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	99,598,987,346.37	99,598,987,346.37
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,559,125,684.08	2,564,205,405.49
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	13,005,849,600.00	13,005,849,600.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(20,867,434,957.71)	(11,002,016,586.86)
2.3.9.1	Тайлангийн үеийн ашиг	20,627,266,827.56	9,865,409,174.85
2.3.9.2	Өмнөх үеийн ашиг	(41,494,701,785.27)	(20,867,425,761.71)
2.3.11	Эздийн өмчийн дүн	94,296,527,672.74	104,167,025,765.00
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	143,818,746,356.25	137,545,907,397.80

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	67,653,283,470.67	62,110,414,135.04
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	42,483,958,509.46	47,549,186,632.04
3	Нийт ашиг (алдагдал)	25,169,324,961.21	14,561,227,503.00
4	Түрээсийн орлого	3,960,000.00	1,479,677.42
5	Хүүний орлого	740,366.91	832,993.22
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	179,935,206.12	1,111,917,868.57
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	2,675,670,738.91	3,662,362,847.11
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	289,637,068.45	744,706,230.98
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	22,388,652,726.88	11,268,388,964.12
19	Орлогын татварын зардал	1,761,385,899.32	1,402,979,789.27
20	Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	20,627,266,827.56	9,865,409,174.85
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	20,627,266,827.56	9,865,409,174.85
23	Бусад дэлгэрэнгүй орлого		-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		-
24	Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	20,627,266,827.56	9,865,409,174.85
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	99,598,987,346.37	2,497,013,552.23	13,005,849,600.00	(41,494,701,785.27)	73,607,148,713.33
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
Залруулсан үлдэгдэл					
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				20,627,266,827.56	20,627,266,827.56
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		62,112,131.85			62,112,131.85
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	99,598,987,346.37	2,559,125,684.08	13,005,849,600.00	(20,867,434,957.71)	94,296,527,672.74
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				9,196.00	9,196.00
Залруулсан үлдэгдэл					
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				9,865,409,174.85	9,865,409,174.85
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		5,079,721.41			5,079,721.41
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	99,598,987,346.37	2,564,205,405.49	13,005,849,600.00	(11,002,016,586.86)	104,167,025,765.00

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1.0	Мөнгөн орлогын дүн (+)	70,328,940,625.76	74,443,572,622.89
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	70,181,548,562.29	73,213,371,216.63
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	22,709,729.00	15,053,061.00
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		1,070,121,900.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	124,682,334.47	145,026,445.26
1.2.0	Мөнгөн зарлагын дүн (-)	43,786,105,479.23	58,599,531,578.40
1.2.1	Ажиллагчдад төлсөн	4,526,304,973.03	6,198,792,697.48
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,865,045,656.48	1,935,733,094.95
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	20,276,985,575.78	23,052,078,050.27
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	6,279,518,654.36	11,167,944,383.58
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	4,581,617,204.80	4,609,909,500.00
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	842,725,889.45	3,455,325,899.42
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	3,677,840,839.12	5,163,953,853.69
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	8,347,825.00	1,353,600.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	1,727,718,861.21	3,014,440,499.01
1.30	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	26,542,835,146.53	15,844,041,044.49
2.00	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(9,042,234,793.84)	
2.10	Мөнгөн орлогын дүн (+)	740,366.91	832,993.22
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	740,366.91	832,993.22
2.20	Мөнгөн зарлагын дүн (-)	9,042,975,160.75	5,418,450,947.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	9,042,975,160.75	5,418,450,947.00
2.30	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(9,042,234,793.84)	(5,417,617,953.78)
3.00	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.10	Мөнгөн орлогын дүн (+)		-
3.20	Мөнгөн зарлагын дүн (-)	13,564,123,947.03	14,383,321,044.56
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	13,564,123,947.03	14,383,321,044.56
3.30	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(13,564,123,947.03)	(14,383,321,044.56)
4.00	Валютын ханшийн зөрүү		
4.10	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	3,936,476,405.66	(3,956,897,953.85)
5.00	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	430,542,180.60	4,367,018,586.26
6.00	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,367,018,586.26	410,120,632.41

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 оны гүйцэтгэл	2024 оны		Өөрчлөлт /өссөн +/, /буурсан -/	
				Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1	Боловсруулсан ДЭХ	мян.Гкал	1,037.3	1,079.7	1,041.1	(38.5)	(3.6)
	Дотоод хэрэгцээний ДЭХ	мян.Гкал	13.0	14.0	14.2	0.2	1.1
	Дулаан түгээлт	мян.Гкал	1,024.2	1,065.7	1,027.0	(38.7)	(3.6)
2	Нийт орлого	мян.төг	67,837,919.0	64,173,867.3	63,224,644.8	(949,222.5)	(1.5)
	Үүнээс: Үйл ажиллагааны орлого	мян.төг	67,653,283.5	63,119,120.1	62,110,414.2	(1,008,705.9)	(1.6)
	Татаас	мян.төг		863,747.2	863,747.2	0	0
	Үйл ажиллагааны бус орлого	мян.төг	184,635.6	191,000.0	250,483.4	59,483.4	31.1
3	Нийт зардал	мян.төг	45,449,266.3	55,436,578.1	51,956,255.7	(3,480,322.4)	(6.3)
	Үүнээс Удирдлагын зардал	мян.төг	87,345.8	160,509.9	149,383.8	(11,126.1)	(6.9)
4	Татварын өмнөх ашиг/алдагдал/	мян.төг	22,388,652.7	8,737,289.2	11,268,389.1	2,531,099.8	29.0
5	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	20,627,266.8	7,863,560.3	10,198,105.9	2,334,545.6	29.7
6	Төрийн өмчийн ногдол ашиг	мян.төг					
7	Нийт ажиллагсдын тоо	хүн	192.0	217.0	217.0	0	0
8	Нийт цалингийн сан	сая.төг	5,584.6	7,467.4	7,389.0	(78.4)	(1.1)
9	Нэг ажиллагчийн дундаж цалин	төгрөг	2,423,871.5	2,867,682.9	2,837,565.7	(30,117.2)	(1.1)
10	Нэгж бүтээгдэхүүний өртөг ДЭХ	төгрөг	44,373.6	52,020.8	50,591.7	(1,429.1)	(2.7)
11	Нэгж бүтээгдэхүүний өртөг ЦЭХ	төгрөг					
12	Борлуулалтын орлогын 1 төг-т ногдох зардал	төгрөг	0.67	0.86	0.82	(0.0)	(4.9)
13	Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ	сая.төг	2,522.6	1,714.6	1,716.5	1.9	0.1
14	Нийт авлага	сая.төг	859.9	800.0	1,068.7	268.7	33.6
	Үүнээс Найдваргүй						
15	Нийт өглөг	сая.төг	49,522.2	30,350.2	33,378.9	3,028.7	10.0
	Богино хугацаат өр төлбөр	сая.төг	17,237.4	4,770.9	11,865.2	7,094.3	148.7
	Урт хугацаат өр төлбөр	сая.төг	32,284.8	25,579.3	21,513.7	(4,065.6)	(15.9)
16	Жишмэл түлшний хувийн зарцуулалт	кг/Гкал	164.9	172.5	171.3	(1.1)	(0.7)

3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1. Аудитаар нийт 61,785.1 сая төгрөгийн алдаа 1 илэрснийг аудитын явцад залрууллаа.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн тодруулгад 61,785.1 сая төгрөг өртөгтэй дуусаагүй барилгыг хойшлогдсон татварын хөрөнгө гэж бүртгэсэн байна.	1	61,785.1			1	61,785.1	1	61,785.1				
Дүн	1	61,785.1			1	61,785.1	1	61,785.1				

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

3.2. Аудитаар нийт 11.0 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж, зөрчлийг нөхөн төлүүлэхээр 9.2 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгуулахаар 1.8 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант онд ажиллагсдад олгосон хоол унааны хөнгөлөлтөөс нийт 1.8 мянган төгрөгийг ҮЭ-ийн татвар суутгасан байна.	1	1,767.1					1	1,767.1				
Сахилгын шийтгэл ногдуулсан 8 ажилтанд нийт 9.2 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна.	1	9,239.2	1	9,239.2								
Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн цаашид ашиглах боломжтой эдийн засгийн үр өгөөж хүртгэж буй 18,443.7 сая төгрөгийн анхны өртөгтэй 601 нэр төрлийн үндсэн хөрөнгийг дахин үнэлүүлээгүй байна.	1	-					1	-				
Дүн	3	11,006.3	1	9,239.2			1	1,767.1				

3.3. АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар зөрчил² илрээгүй.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<i>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</i>								
Амгалан дулааны станц ТӨХК-ийн захиргаа, үйлдвэрчний эвлэлийн хороотой 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдөр байгуулсан 2023-2024 онд хэрэгжүүлэх "Хамтын гэрээ"-ний 3.8-д Шөнийн цагаар ажилласан ажилтанд тухайн ажилтны дундаж цалин хөлсийг 50 хувиар тооцож үндсэн цалин дээр нэмэгдэл хөлс олгоно гэсэн заалт нь Хөдөлмөрийн тухай хуулийн заалттай нийцэхгүй байна.	1	67,900.2			1	67,900.2		
АДС/20240102007 тоот тендерийг 2024.02.21-2024.03.14-ний өдрийг хүртэлх хугацаанд зарлаж, үнэлгээний хороог 6 гишүүнтэй байгуулсан байна. Тус үнэлгээний хорооны гишүүд ажлын даалгавар боловсруулахдаа санхүүгийн тайланг 2022 оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт, ирүүлэх, Борлуулалтын орлого 2022 оны төсөвт өртгийн 80 хувиас багагүй байх, түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээ төсөвт өртгийн 80 хувиас багагүй байна гэж заасан нь 2024 онд зарласан тендерт 2022 оны санхүүгийн тайланг үзүүлэлтээр үнэлэх, татварын өр төлбөр, байгууллагын өр төлбөр, төлбөрийн чадварыг өнөөгийн үнэ цэнээр үнэлэх боломжгүй болгосон байна.	1	-					1	-

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.